163

МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2024 11 29 № 01/ 1434

танай 2024. 11. 06-ны № 33 -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ЭНХТҮВШИН ТАНАА

Танаас ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн "Гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх талаар" 33 дугаар асуулгын хариу мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт .6.. хуудастай.

Хүндэтгэсэн,

Л.ЭНХ-АМГАЛАН

15424169

D: 2024 on 12 sar A5

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1434 дүгээр албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ХАРИУ

1. 2021 онд батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс авсан арга хэмжээ, гаргасан эрх зүйн акт, үр дүн, гүйцэтгэлийн талаар:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д "Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх" гэж заасан.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2022 оны "Журамд нэмэлт оруулах тухай" 80 дугаар тогтоолын дагуу ашигт малтмал болон газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн 50 хувиар хөнгөлөхөөр болсон.

Уг хөнгөлөлтөд 2022 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 270 аж ахуйн нэгж, байгууллагын 4723 гадаадын иргэн ажиллуулсны төлбөрт төлөх байсан 5.7 тэрбум төгрөгийг хөнгөлсөн байна.

Мөн Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул хууль хэрэгжиж эхэлсний дараа ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж баталсан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална." гэж заасны дагуу журмын төслийг уг хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан боловсруулж Засгийн газрын 2023 оны 99 дүгээр тогтоолоор баталсан.

Улмаар 2023 онд 406 аж ахуйн нэгж, байгууллагын 5551 гадаад ажилтан ажиллуулсны ажлын байрны төлбөрийн 50 хувийг хөнгөлж аж ахуйн нэгжүүдэд 7.7 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн бол 2024 оны эхний 10 сарын байдлаар 368 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 7165 гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлсөн байна.

2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг бүрэн чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гүйцэтгэсэн ажлын явцын талаар:

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлого нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрүүдийн нэг болдог бөгөөд уг сангийн хөрөнгөөр хуульд заасны дагуу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хөтөлбөрт суурилсан байдлаар зохион байгуулдаг.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн гадаад иргэдийн ажлын байрны төлбөр /2022-2024 он/

д/д	Огноо	Гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого /төгрөгөөр/
1	2022 он	40,841,109,273.1
2	2023 он	86,920,893,732.6
3	2024 оны эхний 10 сар	81,030,745,433.32

Харин нийтлэг байдлаар бүх салбарт аж ахуйн нэгж, байгууллагыг гадаад ажилтны ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлснөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрөх ёстой орлого бүрдэхгүй байх, дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах бодлогыг уян хатан хэрэгжүүлэх боломж хязгаарлагдахаар байна.

Тус яамнаас Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох болон гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлыг хангах хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын гурван хувь, үүний дотор нэг улсын иргэн нэг хувь хүртэл байж болно." гэж заасныг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгаагаар Монгол Улс 2028 он хүртэл хүн амын насны бүтцээс хамааран ажиллах хүчний хомсдолтой байх үр дүн гарсан.

Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн "Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаа"-гаар 2023 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 26.3 хувь нь ажиллах хүчний хомсдолд орж, шаардлагатай ажилтныг авч ажиллуулж чадаагүй нь судлагдсан.

Тус институтээс 2015-2023 оны хугацаанд жил бүр хийж гүйцэтгэсэн "Барометрийн судалгаа"-ны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дунд, урт хугацааны чиг хандлагыг таамаглан тооцсон.

Энэхүү таамаглалаар 2025 онд хөдөлмөрийн зах зээлд 1.319,0 мянган хүн ажил хөдөлмөр эрхлэх бөгөөд эдийн засгийн өсөлт 4.9 хувийн өсөлттэй байхын тулд 1.407,0 мянган ажиллагч, 7.2 хувийн өсөлттэй байхын тулд 1.420,0 мянган ажиллагч хэрэгцээтэй. Энэ нь 88.0-101.0 мянган ажиллагч хөдөлмөрийн зах зээлд нэмж

нийлүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт нь 2028 онд 108.0-135.5 мянга, 2035 он гэхэд 159.0-228.0 мянга байхаар байна.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт бүрэн чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/176 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Засгийн газрын гишүүд, олон нийтээс санал авах болон бусад ажлыг гүйцэтгэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу холбогдох яамдаас дахин санал авсны үндсэн дээр хэлэлцэхээр тогтсон.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсаны дараа Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эцэслэн боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталж, хуулийн төслийг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг дэмжсэн болно.

Энэ хуулийн төслийг 12 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвшөөрлийг аваад байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох, мөн Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхөөр тусгасан болно.

Мөн аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгохоор тусгасан.

Түүнчлэн гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох хугацаа нь төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байх тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлахаар өөрчилсөн.

Уг хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.5-д тусгагдсан ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх боломжтой болохоор байна.

Засгийн газрын 2023 оны 19, 90, 205, 331, 386 дугаар тогтоолуудаар гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл

ажиллагааг хэрэгжүүлэх 41 аж ахуйн нэгж, байгууллагын 7242 гадаад ажилтныг 2023 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргасан ба уг тогтоолын гүйцэтгэлээр авч үзвэл 34 аж ахуйн нэгж, байгууллагын 4271 гадаад ажилтан ажиллуулсны 7 тэрбум төгрөгийн ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Засгийн газрын 2023 оны 477 дугаар тогтоол, 2024 оны 68 дугаар тогтоолоор 54 аж ахуйн нэгж, байгууллагын 13383 гадаад ажилтныг 2024 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргасан ба уг тогтоолын дагуу 2024 оны эхний 9 сарын байдлаар 40 аж ахуйн нэгж, байгууллагын 7868 гадаад ажилтан ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлсэн.

Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасны дагуу уг хуулийн 21.2.1, 21.2.3, 21.3.1, 22.5-д заасан гадаад ажилтан болон боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагчийг, мөн Чөлөөт бүсийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу гадаад ажилчдыг ажлын байрны төлбөрөөс тус тус чөлөөлж байна. Энэ хүрээнд 2022 онд 287 аж ахуйн нэгж, байгууллагын 1479 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. 2023 онд 225 аж ахуйн нэгж, байгууллагын 1644 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлж аж ахуйн нэгжүүдэд 13.4 тэрбум төгрөгийн чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлсэн байна.

2025 онд гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн, нэгж байгууллагын баримт бичиг, материалыг шалган Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

3. 2024-2028 онд улсын хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрээр ажиллах хүчний хомсдолын тоон төсөөлөл болон авах арга хэмжээний талаар:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох барометрийн 2015-2023 оны судалгааны үр дүнгээс гаргасан эрэлт болон хомсдолын тоон мэдээллийг ашиглан 2024-2028 онуудад хөдөлмөрийн зах зээл дээр нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчдын салбар-ажил мэргэжлийн бүтцийн таамаглалыг боловсруулсан.

Ажиллах хүчний эрэлт эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд хамгийн их, цахилгаан, хий, уур агааржуулалт, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбар эрэлт багатай байна.

2024-2028 онуудад хөдөлмөрийн зах зээл дээр нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчдыг салбараар гаргасан судалгааг хүснэгт 2-оор хүргүүлж байна.

Хүснэгт 2. 2024-2028 онуудад хөдөлмөрийн зах зээл дээр нэмж нийлүүлэх шаардлагатай ажиллагчид салбараар

№	Мэргэжил	Эдийн засагт нийлүүлэх шаардлагатай					Эрэлт					Хомсдол				
		2024	2025	2026	2027	2028	2024	2025	2026	2027	2028	2024	2025	2026	2027	2028
1	ХАА, ойн аж ахуй, загас барилт	19135	22634	24412	26185	27934	1846	1787	1737	1696	1660	1340	1401	1462	1523	1583
2	Уул уурхай, олборлолт	4147	5084	5684	6318	6977	2554	2560	2565	2569	2573	610	640	669	697	724
3	Боловсруулах үйлдвэрлэл	7302	9031	10185	11406	12699	11076	11405	11735	12064	12394	7266	7431	7401	7340	7420
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1427	1785	2036	2295	2588	326	313	301	291	283	63	60	56	53	51
5	Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	514	615	671	728	772	696	737	777	815	852	165	184	204	223	243
6	Барилга	5997	7535	8637	9835	11136	14180	14278	14368	14452	14530	7259	7045	6741	6571	6719
7	Бөөний болон жижиглэн худалдаа. машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	11562	14061	15585	17177	18831	27068	29906	33041	36505	40332	15089	16748	18407	20066	21725
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4263	5053	5460	5849	6245	3257	3356	3455	3554	3653	1166	1259	1352	1445	1538
9	Зочид буудал, байр. сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2580	3207	3636	4097	4593	4401	4989	5494	5812	5896	2382	2582	2782	2982	3182
10	Мэдээлэл, холбоо	1228	1513	1712	1913	2127	2039	2093	2147	2201	2256	1123	1198	1238	1257	1272
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2090	2653	3088	3554	4091	2306	2541	2801	3087	3402	491	569	627	660	670
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	174	232	280	333	406	1112	1123	1134	1144	1153	803	854	905	956	1007

13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1012	1251	1399	1555	1720	6328	7581	8446	8824	8766	2314	2525	2736	2947	3159
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1460	1866	2193	2542	2953	4189	4201	4211	4220	4227	1848	1967	2081	2193	2302
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	6212	7615	8503	9440	10418										
16	Боловсрол	7299	8856	9801	10773	11786	3291	3692	4180	4756	5420	1473	1577	1681	1785	1889
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3492	4206	4609	5022	5446	2513	2442	2370	2299	2227	1269	1308	1344	1379	1412
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	946	1180	1354	1530	1734	534	508	486	466	449	175	169	164	160	156
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2098	2471	2663	2838	3007	2773	3018	3286	3576	3893	2433	2664	2895	3126	3357
Нийт		**82937**	**100848**	**111906**	**123390**	**135464**	**90490**	**96531**	**102536**	**108332**	**113966**	**47268**	**50179**	**52746**	**55363**	**58407**